

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ЧИГ, ҮҮРГИЙГ ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГААР ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ**

2022 оны 2. дугаар
сарын 28.-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.8, Аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 18.1.4 дэх заалт, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 165, 2019 оны 429 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн төрийн байгууллагын зарим чиг, үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор Нэг талаас Сангийн яам, түүнийг төлөөлж Сангийн сайд Б.Жавхлан /цаашид “үүрэг гүйцэтгүүлэгч” гэх/, нөгөө талаас Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт, түүнийг төлөөлж Институтийн ерөнхийлөгч Б.Түвшин /цаашид “үүрэг гүйцэтгэгч” гэх/ нар /хамтад нь “талууд” гэх/ доорх нөхцөлийг харилцан тохиролцож, энэхүү гэрээг /цаашид “Гэрээ” гэх/ байгуулав.

ХОЁР. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 2.1 Гэрээгээр үүрэг гүйцэтгэгч нь дор дурдсан төрийн байгууллагын зарим чиг үүргийг иргэн хуулийн этгээдэд түргэн шуурхай, чанартай гүйцэтгэхэд оршино.
 - 2.1.1. Мэргэшсэн нягтлан бодогч бэлтгэх хөтөлбөр, сургалтын агуулга, сургалт, шалгалтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах;
 - 2.1.2. Аудитын үйл ажиллагааны стандарт, чанарын хяналтыг хэрэгжүүлэх, цахим мэдээллийн санг боловсруулж, хөгжүүлэх;
 - 2.1.3. Мэргэжлийн, мэргэшсэн нягтлан бодогч, аудиторын ёс зүйг сайжруулах, хяналт тавьж хариуцлага тооцох;
 - 2.1.4. Нягтлан бодох бүртгэл, аудитын олон улсын стандарт, түүний нэмэлт, өөрчлөлтийг орчуулах, холбогдох арга, аргачлалыг боловсруулах;
 - 2.1.5. Нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.9. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23.7-д заасан хориг арга хэмжээг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах;
 - 2.1.6. Нягтлан бодох бүртгэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулиар хулээсэн үүргийг

таниулах, хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгаа явуулж, арга зүйн удирдлага, зөвлөгөө, мэдээллээр хангах;

- 2.2 Талууд Гэрээний 2.1.1-д заасан үйл ажиллагааг хамтран зохион байгуулна.
- 2.3 Үүрэг гүйцэтгэгч нь Гэрээний 2.1.4-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ үүрэг гүйцэтгүүлэгч, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран нэгдсэн хяналт хийж болно.
- 2.4 Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1 сарын дотор энэхүү гэрээний 2.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж үүрэг гүйцэтгүүлэгчээр батлуулна.

ГУРАВ. ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Үүрэг гүйцэтгэгчийн үйл ажиллагаа нь холбогдох хууль болон энэ гэрээнд заасны дагуу явагдаж байгаа эсэх талаар дүгнэлт гарган, үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хянан, арга хэмжээ авч, шийдвэр гаргах эрхтэй.
- 3.2 Үүрэг гүйцэтгэгч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгчийн нэг талын санаачилгаар тус гэрээг хэсэгчлэн болон бүхэлд нь хүчингүй болгох бүрэн эрхтэй.
- 3.3 Үүрэг гүйцэтгэгчийн Гэрээнд тусгасан үүргээ гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг Гэрээнд хавсаргаж, гарын үсэг зурж баталгаажуулна.
- 3.4 Үүрэг гүйцэтгэгчийн Гэрээнд тусгасан үүргээ гүйцэтгэхэд бодлогын дэмжлэг үзүүлж болно.

ДӨРӨВ. ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай үйл ажиллагааны зохион байгуулалтад үүрэг гүйцэтгүүлэгчээс туслалцаа, дэмжлэг авах эрхтэй.
- 4.2 Гэрээний 2.1-д заасан чиг үүргийг цаг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэж, үүрэг гүйцэтгүүлэгчид тайлгнах үүрэгтэй.
- 4.3 Гэрээ болон ажлын төлөвлөгөөний биелэлтийг үүрэг гүйцэтгүүлэгчид тухайн оны 12 дугаар сарын 5-ны өдрийн дотор бичгээр ирүүлж дүгнүүлнэ.

ТАВ. ТАЛУУДЫН НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1 Талууд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гэрээний нөгөө талаас шаардах эрхтэй.
- 5.2 Гэрээний биелэлтийг хангахад технологийн болон эрх зүйн орчинд өөрчлөлт шинэчлэлт гарсан тохиолдолд хамтын ажиллагааг тэдгээрт нийцүүлэх талаар санаачилга гаргаж ажиллана.
- 5.3 Талууд Гэрээний үүргийн биелэлтийг 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор гаргаж 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор дүгнэнэ.

ЗУРГАА. ДЭМЖЛЭГ

- 6.1 Үүрэг гүйцэтгүүлэгч нь 2.1-д заслан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүрэг гүйцэтгэгчид олон улсын байгууллагын техник, туслалцааны төслийн шугамаар гадаад болон дотоодын зөвлөх үйлчилгээгээр хангах, дэмжлэг үзүүлж болно.

ДОЛОО. ХАРИУЦЛАГА

- 7.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх явцад холбогдох хууль тогтоомж зөрчигдсөн байх болзошгүй тохиолдолд илэрсэн зөрчил дутагдлыг харилцан мэдээлэх, зөрчлийг арилгах талаар хамтран ажиллана.
- 7.2 Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс талуудын хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн тохиолдолд Гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн тал хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

НАЙМ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1 Гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан гарах аливаа маргааныг талууд харилцан зөвшилцэж шийдвэрлэнэ.
- 8.2 Хэрэв талууд харилцан зөвшилцэж чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1 Гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2 Гэрээг 3 хувь үйлдэж гүйцэтгэгч тал 1 хувь, гүйцэтгүүлэгч тал 2 хувийг тус тус хадгалах бөгөөд эх хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.
- 9.3 Талууд энэхүү Гэрээгээр хүлээх эрх үүргээ бүхэлд нь эсвэл хэсэгчлэн бусдад шилжүүлэхгүй.
- 9.4 Гэрээний талуудын үйл ажиллагааны чиглэл, нэр, удирдлага зохион байгуулалтад аливаа өөрчлөлт орсон тохиолдолд тухайн үйл ажиллагааг залгамжлан хэрэгжүүлэх байгууллага нь Гэрээний эрх, үүргийг шууд хүлээн авах ба Гэрээний үүрэг заавал биелэгдэх шинжтэй байна.
- 9.5 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр хийх бөгөөд Гэрээнд оролцогч бүх Талуудын эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр гэж тооцогдоно. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Гэрээний нэгэн адил хүчинтэй байж, түүний салшгүй хэсэг байна.
- 9.6 Гэрээгээр зохицуулаагүй бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоор зохицуулж, түүнийг удирдлага болгоно.
- 9.7 Гэрээ нь гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр байна.

- 9.8 Гэрээний хүчинтэй хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө гэрээний аль нэг тал цуцлах талаар бичгээр санал гаргаагүй бол Гэрээг тухай бүр дахин нэг жилийн хугацаагаар сунгагдсанд тооцно.
- 9.9 Гэрээг шинэчлэн байгуулсантай холбогдуулан талуудын хооронд 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан 118 дугаартай гэрээг дүгнэж дуусгавар болгов.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

САНГИЙН ЯАМЫГ ТӨЛӨӨЛЖ:



САНГИЙН САЙД
Б.ЖАВХЛАН

МОНГОЛЫН МЭРГЭШСЭН НЯГТЛАН
БОДОГЧДЫН ИНСТИТУТИЙГ
ТӨЛӨӨЛЖ:

ИНСТИТУТИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ
Б.ТҮВШИН



БАТЛАВ: САНГИЙН ЯМНЫ НЯГТЛАН БОДОХ
БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Болормаа

Б.БОЛОРМАА

МОНГОЛЫН МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧДЫН ИНСТИТУТИЙН
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2022 оны 3-р сарын 1..-ний өдөр

Гэрээний заалт	Үйл ажиллагаа	Хугацаа	Хүрэх үр дүн
2.1.1 Мэргэшсэн нягтлан бодогч бэлтгэх хөтөлбөр, сургалтын агуулга, сургалт, шалгалтын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэх, шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах;	1. Монгол Улсын Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох шалгалтын журамд саналаа хүргүүлэх 2. Мэргэшсэн нягтлан бодогчийг бэлтгэх шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангуулах 3. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох болон сунгах шалгалтыг цахим хэлбэрээр авах 4. Мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох болон сунгах шалгалтын тестийн санг баяжуулах	2-р улирал	Журмын төсөлд саналаа хүргүүлсэн байна.
2.1.2 Аудитын үйл ажиллагааны стандарт, чанарын хяналтыг хэрэгжүүлэх, цахим мэдээллийн санг боловсруулж, хөгжүүлэх;	5. Аудитын компаниудад хийх чанарын хяналтын үр нэлөөг сайжруулах зорилгоор чанарын хяналтыг хэрэгжүүлж ирсэн өнгөрсөн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх 6. Аудитын компаниудад хийх чанарын хяналтыг хамтран зохион байгуулах	2-р улиралд	Чанарын хяналтын үр нэлөөг сайжруулах чиглэлээр санал боловсруулсан байна.
	7. Олон Улсын Чанарын Удирдлагын Стандарт 1, 2 батлагдсантай холбогдуулан тэдгээрийн стандартыг нэвтрүүлэх бэлэн байдлын үнэлгээг аудитын компаниудад хийх 8. Олон Улсын Чанарын Удирдлагын Стандарт 1, 2	3-р улирал	Аудитын компаниудын 80-иас доошгүй хувийг хамруулж бэлэн байдлын үнэлгээний тайланг бэлтгэсэн байна.
		4-р улирал	Бүх аудитын компаниудад цахим

	-ийг танилцуулах сургалтыг аудитын компаниудад хийх		болон танхимын сургалт явуулсан байна.
	9. Тусгай зөвшөөрлийн цахим систем /https://license.mof.gov.mn/-ийн Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн модуль сайжруулалтыг дэмжиж, хамтран ажиллах	Жилийн турш	Системд хөгжүүлэлт хийх чиглэлээр хамтран ажилласан байна.
2.1.3 Мэргэжлийн, мэргэшсэн нягтлан бодогч, аудиторын ёс зүйг сайжруулах, хяналт тавьж хариуцлага тооцох	10. Гишүүн байгууллагуудад өгөх ёс зүйн тодорхойлолтыг цахимд шилжүүлэх	3-р улиралд	Ёс зүйн тодорхойлолтыг цахим хэлбэрээр гаргадаг болсон байна.
	11. Шинээр батлагдсан Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандартыг Багтаасан)-ийн цахим хичээлийн хөтөлбөр боловсруулж, сургалт явуулах, олон нийтэд сурталчлан таниулах	2 ба 3 дугаар улиралд	Гишүүдэд болон олон нийтэд зориулан цахим ба хэвлэмэл байдлаар 5-аас доошгүй удаа сургалт хийж, сурталчлан таниулсан байна.
	12. Гишүүдийн ёс зүйн зөрчил, маргааныг хянан шийдвэрлэх, хариуцлага тооцох чиглэлээр ММНБИ-ийн УЗ-ийн дэргэдэх хараат бус Мэргэжлийн Хариуцлагын Хороотой хамтран ажиллаж холбогдох мэдээллийн санг бүрдүүлнэ.	Жилийн турш	Гишүүдийн ёс зүйн зөрчил, маргааныг шуурхай шийдвэрлүүлж, хариуцлага тооцдог болсон байна.
2.1.4 Нягтлан бodoх бүртгэл, аудитын олон улсын стандарт, түүний нэмэлт, өөрчлөлтийг орчуулах, холбогдох арга, аргачлалыг боловсруулах;	13. Олон Улсын Чанарын Удирдлагын Стандарт 1, 2-ыг орчуулж, Сангийн сайдын дэргэдэх НББАСХ-оор батлуулах	2-р улирал	Чанарын удирдлагын стандартуудыг батлуулсан байна.
	14. АБОУС-ын 2020 оны хэвлэлийн 3 ботийг орчуулан, Сангийн сайдын дэргэдэх НББАСХ-оор батлуулж, хэвлүүлэх	3-р улирал	Батлагдсан стандартуудыг хэвлүүлж, холбогдох талуудад хүргүүлсэн байна
	15. СТОУС 2021 оны Б Хэсэг буюу “Хэрэгжүүлэх заавар удирдамж”-ийг бүрэн орчуулж гаргах	4-р улирал	Удирдамжийг бүрэн орчуулж, хэвлэлтэд өгсөн байна
2.1.5 Санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь Мөнгө угаах болон терроризмыг	16. Эрсдэлийн үнэлгээ, зайны болон газар дээрх хяналт шалгалтын үр дүн болон бусад мэдээлэл,	1-р улиралд	МҮЭ-ийн эрсдэлийн зэрэглэл, газар дээрх хяналт шалгалтын

санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.9. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмий тэмцэх тухай хуулийн 23.7-д заасан хориг арга хэмжээг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах;	эрсдэлийн үнэлгээ/скоринг-д үндэслэн МҮЭ-ийн эрсдэлийн зэрэглэл, газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөг жил бүр шинэчлэн батлах		төлөвлөгөөг баталсан байна.
	17. Батлагдсан төлөвлөгөөний дагуу МҮЭ-ийн мэнгэ угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд суурисан бодлого, журам хэрэгжүүлж байгаа эсэхэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийж, хяналт тавих	2 ба 3-р улирал	Батлагдсан төлөвлөгөөний дагуу салбар бүрээс 10-аас доошгүй МҮЭ-дэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийсэн байна.
	18. Зайны болон газар дээрх хяналт шалгалтын үр дүнд үндэслэн дутагдлыг арилгах чиглэлээр анхааруулга, зөвлөмж өгөх, гаргасан зөрчилд нь тохирсон, дахин үйлдэхээс сэргийлэхүйц арга хэмжээ авах	4-р улирал	Хяналт шалгалтын дүнд үндэслэн арга хэмжээ авсан байна.
	19. Эрсдэлд суурисан хяналт шалгалтын үр дүн болон бусад шаардлагатай мэдээллийг МБ-ны СМА болон СЯ-нд тухай бүр хүргүүлж байх	жилийн турш	Ажлын гүйцэтгэл, дүнг баримтжуулж, жилийн дүнгээр нэгдсэн тайлан гаргасан байна.
	20. МҮЭ-ийн эрсдэлийг үнэлэх матрицыг МУТС суурь эрсдэл, эмзэг сул тал болон эрсдэлийг бууруулах арга хэмжээний үр дүнг харгалзан тухай бүр өөрчилж шинэчлэн, боловсронгуй болгох	жилийн турш	Эрсдэлийн үнэлгээний матрицыг 1-ээс доошгүй удаа шинэчилсэн байна.
	21. МҮЭ-д зориулан байгууллагын эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийж гүйцэтгэх талаарх зөвлөмж, заавар гаргах	Жилийн турш	Зөвлөмж, заавар 1-ээс доошгүй боловсруулж, хүргүүлсэн байна.
2.1.6 Санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн Мэнгэ угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмий	22. FATF болон бусад эрх бүхий байгууллагаас гаргасан мэдээлэл, материалыг холбогдох мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд шуурхай хүргэх, мэдээллээр хангах	жилийн турш	Мэдээлэл, материалыг шуурхай хүргэсэн байна.
	23. МҮЭ-ийн комплаенсын	жилийн	Салбар, мэргэжлээр

тэмцэх тухай хуулиар хүлээсэн үргийг таниулах, хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгаа явуулж, арга зүйн удирдлага, зөвлөгөө, мэдээллээр хангах;	ажилтнуудын МУТСТ үүрэг, хариуцлагын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, зорилтот түвшинд хүргэх сургалт, сурталчилгааны ажлууд зохион байгуулах	турш	төрөлжүүлсэн сургалт 2-оос доошгүй удаа явуулж, тайлан гарсан байна.
	24. МҮЭ-д МУТСТ хууль тогтоомжид орсон өөрчлөлт, шинэчлэлтийн талаар тухай бүр танилцуулж байх	жилийн турш	Цахим болон хэвлэмэл байдлаар 3-аас доошгүй удаа мэдээлэх, сурталчлах ажил хийсэн байна.
	25. FATF-аас зөвлөсний дагуу улирал бүр мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны дутагдалтай улсуудын талаарх мэдээллийг МҮЭ-д хүргүүлж байх.	жилийн турш	Мэдээллийг тухай бүр МҮЭ-д хүргүүлсэн байна.

Нийтээ нийтийн Т үзүүлэлтэд олонд орсон хөдөлгөөнүүдийн тийрлэгээний төрөлжүүлэхийн төслийн төсөө	Ихэвхижүүлэх	Нийтээ нийтийн Т үзүүлэлтэд олонд орсон хөдөлгөөнүүдийн тийрлэгээний төрөлжүүлэхийн тийрлэгээний төрөлжүүлэхийн төслийн төсөө
Нийтээ нийтийн Т үзүүлэлтэд олонд орсон хөдөлгөөнүүдийн тийрлэгээний төрөлжүүлэхийн төслийн төсөө	Ихэвхижүүлэх	Нийтээ нийтийн Т үзүүлэлтэд олонд орсон хөдөлгөөнүүдийн тийрлэгээний төрөлжүүлэхийн тийрлэгээний төрөлжүүлэхийн төслийн төсөө
Нийтээ нийтийн Т үзүүлэлтэд олонд орсон хөдөлгөөнүүдийн тийрлэгээний төрөлжүүлэхийн төслийн төсөө	Ихэвхижүүлэх	Нийтээ нийтийн Т үзүүлэлтэд олонд орсон хөдөлгөөнүүдийн тийрлэгээний төрөлжүүлэхийн тийрлэгээний төрөлжүүлэхийн төслийн төсөө
Нийтээ нийтийн Т үзүүлэлтэд олонд орсон хөдөлгөөнүүдийн тийрлэгээний төрөлжүүлэхийн төслийн төсөө	Ихэвхижүүлэх	Нийтээ нийтийн Т үзүүлэлтэд олонд орсон хөдөлгөөнүүдийн тийрлэгээний төрөлжүүлэхийн тийрлэгээний төрөлжүүлэхийн төслийн төсөө
Нийтээ нийтийн Т үзүүлэлтэд олонд орсон хөдөлгөөнүүдийн тийрлэгээний төрөлжүүлэхийн төслийн төсөө	Ихэвхижүүлэх	Нийтээ нийтийн Т үзүүлэлтэд олонд орсон хөдөлгөөнүүдийн тийрлэгээний төрөлжүүлэхийн тийрлэгээний төрөлжүүлэхийн төслийн төсөө